



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 06

Баянхутаг


**Дотоод хяналт шалгалт
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Дотоод хяналт шалгалтын ажилтан”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Дотоод хяналт хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолт”-ыг гуравдугаар хавсралтаар, “Дотоод хяналт шалгалтын 2024 оны жилийн ажлын төлөвлөгөө”-г дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Дотоод хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, улирал бүр үр дүнг тайлагнан, тушаалын хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт шалгалтын ажилтан /О.Дэлгэржаргал/-д даалгасугай.

ДАРГА



С.МӨНХХЭРЛЭН